**БАТЛАВ.** САНГИЙН ДЭД САЙД БӨГӨӨД
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТЫН
СТАНДАРТЫН ХОРООНЫ ДАРГА С.МӨНГӨНЧИМЭГ

**НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТЫН СТАНДАРТЫН ХОРООНЫ 21 ДҮГЭЭР ХУРАЛДААН**

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. СТОУС-ын 2021 оны хэвлэлийн Б хэсэг буюу "Хэрэгжүүлэх заавар, удирдамж"-ийн орчуулгыг хэлэлцэн, батлах (945 хуудас);
2. НББАСХ-оор батлагдсан стандартуудыг хэвлэх, борлуулах, давтан сургах чиглэлээр ММНБИ-ийн гүйцэтгэж байгаа үйл ажиллагааны тайлан сонсох;
3. Бусад.

-o0o-

Хурал 2024 оны 01 дүгээр сарын 08-ний өдрийн 15⁰⁰ цагт Сангийн яамны 9 давхрын Чагдаржавын танхимд эхлэнэ.

# САНГИЙН САЙДЫН ДЭРГЭДЭХ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТЫН СТАНДАРТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 01 дүгээр
сарын 08-ны өдөр №17 Улаанбаатар хот

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 21 дүгээр зүйл болон Сангийн сайдын 2016 оны 323 дугаар тушаалыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. СТОУС-ын 2023 оны хэвлэлийн Б хэсэг буюу "Хэрэгжүүлэх заавар, удирдамж"-ийн монгол орчуулгын бүрэн эхийг хавсралтаар баталсугай.
2. СТОУС-ын 2023 оны хэвлэлийн Б хэсэг буюу "Хэрэгжүүлэх заавар, удирдамж"-ийн монгол орчуулгыг олон нийтэд хүргэх арга хэмжээг 2024 оны 06 дугаар сард багтаан хэрэгжүүлж, үр дүнг танилцуулахыг Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт /Б.Оюунбаатар/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Б.Болормаа/-т үүрэг болгосугай.

САНГИЙН ДЭД САЙД БӨГӨӨД
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТЫН
СТАНДАРТЫН ХОРООНЫ ДАРГА С.МӨНГӨНЧИМЭГ

**САНГИЙН САЙДЫН ДЭРГЭДЭХ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТЫН СТАНДАРТЫН ХОРООНЫ ТОГТООЛ**

2024 оны 01 дүгээр
сарын 08-ны өдөр №18 Улаанбаатар хот

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 21 дүгээр зүйл болон Сангийн сайдын 2016 оны 323 дугаар тушаалыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар батласугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Б.Болормаа/-т үүрэг болгосугай.

САНГИЙН ДЭД САЙД БӨГӨӨД
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТЫН
СТАНДАРТЫН ХОРООНЫ ДАРГА С.МӨНГӨНЧИМЭГ

Сангийн сайдын дэргэдэх нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2024 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 18 дугаар тогтоолын хавсралт

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТЫН СТАНДАРТЫН ХОРООНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хийх ажил | Хамтарч ажиллах байгууллага | Хугацаа | Хариуцах ажилтан |
|---|---|---|---|---|
| 1. | НББАСХ-ны 2023 оны тайлан, 2024 оны төлөвлөгөөг боловсруулж, батлах | - | 1 дүгээр сард | Э.Буянхишиг |
| 2. | СТОУС-ын 2021 оны хэвлэлийн Б хэсэг буюу "Хэрэгжүүлэх заавар, удирдамж"-ийн орчуулгыг хэлэлцэн, батлах (945 хуудас) | ММНБИ | 1 дүгээр сард | Хорооны гишүүд |
| 3. | НББАСХ-оор батлагдсан стандартуудыг хэвлэх, борлуулах, давтан сургах чиглэлээр ММНБИ-ийн гүйцэтгэж байгаа үйл ажиллагааны тайлан сонсох | ММНБИ | 1 дүгээр сард | ММНБИ Хорооны гишүүд |
| 4. | СТОУС-ын Тогтвортой байдлын тодруулгын стандарттай холбоотой нэр томьёог хэлэлцүүлэх | - | 2 дугаар сар | Л.Бадамханд Н.Мөнхцацрал |
| 5. | СТОУС-ын шинэчлэлт, өөрчлөлтүүд БОНЗ-ын тогтвортой байдлын талаарх судалгаа хийж, танилцуулах | - | 4 дүгээр сард | Хорооны гишүүд |
| 6. | "Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, шалгалт авах журам"-ын төслийг танилцуулах | ММНБИ | 4 дүгээр сард | Хорооны гишүүд |
| 7. | "Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны маягтын загвар, түүнийг хөтлөх аргачлал"-ын төслийг танилцуулах | НДЕГ | 4 дүгээр сард | Хорооны гишүүд |
| 8. | "СТОУС-ын Тогтвортой байдлын тодруулгын стандарт- Тогтвортой байдалд хамаарах санхүүгийн мэдээллийг тодруулах ерөнхий шаардлага"-ын орчуулгыг хэлэлцэн, батлах (48 хуудас) | ММНБИ | 6 дугаар сард | Хорооны гишүүд |
| 9. | "СТОУС-ын Тогтвортой байдлын тодруулгын стандарт- Уур амьсгалтай холбоотой тодруулга"-ын орчуулгыг хэлэлцэн, батлах (46 хуудас) | ММНБИ | 6 дугаар сард | Хорооны гишүүд |
| 10. | "Нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргах журам"-ын шинэчилсэн төслийг танилцуулах | - | 6 дугаар сард | Хорооны гишүүд |
| 11. | "Үл хөдлөх үнэлгээний журам, | - | 11 дүгээр сард | Хорооны гишүүд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | аргачлал"-ын төслийг танилцуулах | | | |
| 12. | "Хөдлөх хөрөнгийн үнэлгээний журам аргачлал"-ын төслийг танилцуулах | - | 11 дүгээр сард | Хорооны гишүүд |
| 13. | "Санхүүгийн тайлагналын зориулалттай үнэлгээний журам, аргачлал"-ын төслийг танилцуулах | - | 11 дүгээр сард | Хорооны гишүүд |
| 14. | Аудитын хуулийн этгээдэд хийсэн чанарын дүнг хэлэлцэх | - | 11 дүгээр сард | Хорооны гишүүд |
| 15. | НББАСХ-оор батлагдсан стандартуудыг хэвлэх, борлуулах, давтан сургах чиглэлээр ММНБИ-ийн гүйцэтгэж байгаа үйл ажиллагааны тайлан сонсох | ММНБИ | 11 дүгээр сард | Хорооны гишүүд |

-o0o-